

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ХАЛАМЖИЙН САНГИЙН 2020 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Аудитын код: ХОА-2021/1/СТА-ЗГТС

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Ховд хот 2021 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 70433061 Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас:70432545 Цахим хаяг: Tsetsegsuren.A@audit.gov.mn Ахлах аудитор: Ц.Гантулга Утас: 70432545 цахим хаяг: Gantulga.TS@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

<i>АДБОУС</i>	<i>Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт</i>
<i>АОУС</i>	<i>Аудитын Олон Улсын Стандарт</i>
<i>УСНББОУС</i>	<i>Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт</i>
<i>ТТЗ</i>	<i>Төсвийн төвлөрүүлэн захирагч</i>
<i>ТШЗ</i>	<i>Төсвийн шууд захирагч</i>
<i>ХНХ</i>	<i>Хөдөлмөр нийгмийн хамгаалал</i>
<i>ЭМ</i>	<i>Эрүүл мэнд</i>
<i>ЭХМК</i>	<i>Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс</i>
<i>ХХҮГ</i>	<i>Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар</i>

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	Error! Bookmark not defined.
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	4
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	6
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	Error! Bookmark not defined.
3. Аудитын тайлан.....	7
3.1. Ерөнхий зүйл.....	7
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	7
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт	7
3.4. Материаллаг байдал	8
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	8
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	9
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	9
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	9
3.9. Аудитын илрүүлэлт.....	9
Залруулсан алдаа.....	10
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	
Аудитын зөвлөмж.....	Error! Bookmark not defined.
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	10
4. Менежментийн захидал.....	10
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	11

1. ТӨРИЙН АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

ХӨДӨЛМӨР ХАЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ГАЗРЫН ДАРГА Л.БИЛЭГДЭМБЭРЭЛ ТАНАА

2021.02.04 № 242
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны Ховд аймгийн Халамжийн нэгтгэсэн сангийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Ховд аймгийн Халамжийн нэгтгэсэн сангийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Ховд аймгийн Халамжийн нэгтгэсэн сангийн 2020 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.БОЛДБААТАР



021020242

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

			/Төгрөгөөр/
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1392000.41</u>	<u>545166.40</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	0.41	545166.40
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	0.41	545166.40
3121	Төгрөг	0.41	545166.40
31213	Арилжааны банк дахь харилцах	0.41	545166.40
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1392000.41</u>	<u>545166.40</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>24000.00</u>	<u>24000.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	24000.00	24000.00
413	Өглөг	24000.00	24000.00
4136	Бусад өглөг	24000.00	24000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	24000.00	24000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1368000.41</u>	<u>521166.40</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1368000.41	521166.40
512	Хуримтлагдсан үр дүн	1368000.41	521166.40
51210	Өмнөх үеийн үр дүн	-214380163.18	1368000.41
51220	Тайлант үеийн үр дүн	215748163.59	-846834.01
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1392000.41</u>	<u>545166.40</u>

2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

			/Төгрөгөөр/
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	<u>14078606888.52</u>	<u>13683305929.28</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	<u>43749878.52</u>	<u>6980629.28</u>
120	Нийтлэг татварын бус орлого	43749878.52	6980629.28
120002	Хүүгийн орлого	16615578.52	6980629.28
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	<u>14034857010.00</u>	<u>13676325300.00</u>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	13793476110.00	13521444400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	13793476110.00	13521444400.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	241380900.00	154880900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	241380900.00	154880900.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	<u>13862858724.93</u>	<u>13684152763.29</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	<u>13862858724.93</u>	<u>13684152763.29</u>
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13862858724.93	13684152763.29
2132	Бусад урсгал шилжүүлэг	13822109773.00	13499499118.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	13822109773.00	13499499118.00

2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	40729166.22	135703578.12
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	40729166.22	135703578.12
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	19785.71	48950067.17
213402	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт сумдад		
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	19785.71	48950067.17
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	215748163.59	-846834.01
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	215748163.59	-846834.01

2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	14,078,606,888.52	13,709,431,471.28
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	43,749,878.52	33,106,171.28
120	Нийтлэг татварын бус орлого	43,749,878.52	33,106,171.28
120002	Хүүгийн орлого	16,615,578.52	6,980,629.28
120009	Бусад орлого	27,134,300.00	26,125,542.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	14,034,857,010.00	13,676,325,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	13,793,476,110.00	13,521,444,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	13,793,476,110.00	13,521,444,400.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	241,380,900.00	154,880,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	241,380,900.00	154,880,900.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	14,078,663,864.93	13,708,886,305.29
21	УРСГАЛ ЗАРДАЛ	14,078,663,864.93	13,708,886,305.29
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,078,663,864.93	13,708,886,305.29
2132	Бусад урсгал шилжүүлэг	14,037,914,913.00	13,524,232,660.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	14,037,914,913.00	13,524,232,660.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	184,653,645.29
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		184,653,645.29
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	(56,976.41)	545,165.99
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(56,976.41)	545,165.99

9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	56,976.82	0.41
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.41	545,166.40

2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			-69,089,719.59	-69,089,719.59
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	-69,089,719.59	-69,089,719.59
C07	Тайлант үеийн үр дүн			70,457,720.00	70,457,720.00
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	1,368,000.41	1,368,000.41
D01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	1,368,000.41	1,368,000.41
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	1,368,000.41	1,368,000.41
D08	Тайлант үеийн үр дүн			-846,834.01	-846,834.01
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	521,166.40	521,166.40

2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны / төгрөгөөр /	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		0.41
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	13,708,886,305.29
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	13,708,886,305.29
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	13,708,886,305.29
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	13,708,886,305.29
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж		13,708,886,305.29
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	13,676,325,300.00	13,709,431,471.28
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	13,521,444,400.00	13,521,444,400.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	13,521,444,400.00	13,521,444,400.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	154,880,900.00	154,880,900.00
132001	Орон нутгийн төсвөөс	154,880,900.00	154,880,900.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	33,106,171.28
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих /хүүгийн орлого/		6,980,629.28
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих /буцаасан орлого/		26,125,542.00

4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		0.41
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		545,166.40

3. АУДИТЫН ТАЙЛАН

3.1. Ерөнхий зүйл

Халамжийн сангийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг дарга Л.Билэгдэмбэрэл танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд асаргааны тэтгэмж олголтын талаар өгсөн зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 03-ны хооронд Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ц.Гантулга хариуцаж хэрэгжүүлэв.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Халамжийн сан нь “Нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот өрх, иргэдэд түргэн шуурхай чирэгдэлгүй хүргэх, нийгмийн халамжийн үйлчилгээг чанартай, үр дүнтэй, шуурхай хүргэх замаар нийгмийн тогтвортой хөгжлийг хангахад чиглэгдсэн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний төрийн бодлогыг орон нутагт хэрэгжүүлэн ажиллахад оршино.” гэж тодорхойлжээ. Үүнд:

- *Нутаг дэвсгэртээ хууль тогтоомжийг хэрэгжүүлэх*
- *Засгийн газрын шийдвэр харьяалах дээд шатны шийдвэрийг гүйцэтгэлийг хянах*
- *Харьяа яамны сайдын тушаал, шийдвэрийг хэрэгжүүлэх*
- *Нийгмийн халамжийн тэтгэвэр*
- *Нийгмийн халамжийн тэтгэмж*
- *Нийгмийн халамжийн үйлчилгээ*
- *Нийгмийн хөгжлийн үйлчилгээ*

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт*
- *Нийгмийн халамжийн багц хуулиудын өөрчлөлт*
- *Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолын өөрчлөлт*
- *Засгийн газрын 2018 оны 31 дүгээр тогтоолын өөрчлөлт*

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Халамжийн сангийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газрын хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэс болон аймгийн ЗДТГ-ын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар 2020 онд тус байгууллагад дотоод хяналт хийгдээгүй байна. Харин ХХҮГ-ын захиргаа хяналтын хэлтэс дотоод хяналтаа хэрэгжүүлсэн байна.

Байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд БАГА гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр **нийт зардлыг** сонгож, эрсдэлийн түвшнийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлын 13104368.1 мянган төгрөгөөс 2 хувиар тооцон 262087.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон.

Харин гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардал 13684152.7 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 136841.5 мянган төгрөгөөр материаллаг байдлын хувийг бууруулсан нь гүйцэтгэлийн үе шатанд аудитын эрсдэлийг багасгах зорилгоос шалтгааллаа.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Халамжийн сангийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 846.8 мянган төгрөгөөр буюу 60.8 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, мөнгөн хөрөнгө, засгийн газрын оролцооны данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.41	545.2	544.8
Авлага	1392.0	0	-1392.0
Нийт хөрөнгө	1392.0	545.2	-846.8
Өр төлбөр	24.0	24.0	0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1368.0	521.2	-846.8
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1392	545.2	-846.8

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өссөн нь оны төгсгөлд ХААН банкны хуримтлагдсан хүү 12 сарын 31-нд банкны гүйлгээ хаагдсаны дараа бодогдож хүүгийн орлого орсонтой холбоотой байна.

Авлага дансанд өнгөрсөн оны тэтгэмжийн авлагыг барагдуулснаас буурсан байна.

Өр төлбөр оны эхний 24.0 мянган төгрөг оны эцэст үлдсэн нь амьжиргааг дэмжих зөвлөлийн урамшууллын 10 хувийн татварын өглөг үүссэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны оны эхний үлдэгдэл 1368.0 мянган төгрөг байсан нь тайлант онд 521.2 мянган төгрөг болж 846.8 мянган төгрөгөөр буурсан өөрчлөлттэй байна.

Халамжийн сангийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар улсын төсвийн санхүүжилт өмнөх оноос 272031.7 мянган төгрөгөөр буюу 0.02 хувиар буурсан байна.

Дээрх үзүүлэлт нь зарим төрлийн халамжийн үйлчилгээнүүд “И-халамж” цахим системээр дамжин Сангийн яамнаас иргэдийн нэрийн данс руу шууд хөрвөдөг болсонтой холбоотой байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт:

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 13676325.3 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 13676325.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн гүйцэтгэл:

Тайлант онд 13676325.3 мянган төгрөгийн төсөв баталснаас 13521444.4 мянган төгрөгийг улсын төсвөөс, 154880.9 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 13521444.4 мянган төгрөг, буцаалтын орлогоос 26125.5 мянган төгрөг, хүүгийн орлого 6650.3 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 154880.9 мянган төгрөгийн санхүүжилт түүний хүү 330.3 мянган төгрөг бүрдүүлж, 184653.6 мянган төгрөгийг улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 148 мэдээлэл, 3 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш дүн бүхий орлого буюу сар бүрийн санхүүжилтийн орлого, зарлагын 22 гүйлгээ гарсныг тухай бүр шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 2350.0 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгөгдөж зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 635.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 635.6 мянган төгрөгийн нөхөн олгох төлбөрийн акт, алдаа зөрчлийг арилгах 1 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаа илэрсэнгүй.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 635.6 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрсэн тул 1 нөхөн олгох төлбөрийн акт тогтоолоо.

1. Асаргааны тэтгэмж олгохдоо зарим иргэдийн аймгийн ЭХМКомиссын акт болон сумын эрхлэгч их эмчийн тодорхойлолтын хугацаа баримтлаагүйгээс тэтгэмж дутуу олгогдсон нь Нийгмийн халамжийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.6, ЭМ-ийн сайд, ХНХ-ын сайдын 2018 оны 2 дугаар сарын 23-ны өдрийн А/69/48 тушаалын 4 дүгээр хавсралтад заасны дагуу “Байнгын асаргаанд байх хугацаа дууссан өдрөөс хойш ахмад настан, ХБИ-ний асаргааг ажлын 10 хоногийн дотор сунгуулах бөгөөд хүндэтгэн үзэх шалтгаангүй тохиолдолд комиссын хурлаар орсон өдрөөс тооцон хугацааг сунгана.” Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас өмнө хянан, баталгаажуулах” гэсэн хуулийн заалт, Аудитын олон улсын стандартын -300, “Үнэн зөв байдал”, “Иж бүрэн” байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нөхөн олгох төлбөрийн акт тогтоов.

4.0. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. **Халамжийн сангийн асаргааны тэтгэмжийн талаар**

1.1. Илрүүлэлт: Засгийн газрын 2012 оны 185 дугаар тогтоолд заасны дагуу үйлчилгээ авч буй иргэдийг сумаас аймагт ирж оношоо баталгаажуулж тодорхойлолт гаргуулахыг шаарддагаас улбаатай иргэдийг чирэгдүүлэх, тухайн иргэн зардал мөнгөөр хохирох нөхцөл үүсдэг, нөгөө талаас оношны баталгаажуулалтгүйгээс сангийн хөрөнгийн үр өгөөж буурахаар байна.

1.2. Эрсдэл: Нийгмийн халамжийн хууль, тогтоомжийн холбогдох заалт хэрэгжихгүй байх

1.3. Өгсөн зөвлөмж Засгийн газрын 2012 оны 185 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтыг мөрдөх, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдэд олгох тэтгэмжийн үндсэн баримт болох сум, аймгийн эмч нарын оношны заалтын үндэслэлийг газрын дотоод хяналт хийх явцдаа нарийн мэргэжлийн эмчийн оролцоотойгоор дүгнэлт гаргуулан баталгаажуулж байх

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ

Огноо:	Аудитын нэр:	Халамжийн ангийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудит	Аудитын код:
2021			ХОА-2021/1/СТА-ЗГТС
Шалгагдсан байгууллагын нэр:	Хөдөлмөр Халамж үйлчилгээний газар		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	2	3	4	5	5
1	Засгийн газрын 2012 оны 185 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтыг мөрдөх, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдэд олгох тэтгэмжийн үндсэн баримт болох сум, аймгийн эмч нарын оношны заалтын үндэслэлийг газрын дотоод хяналт хийх явцдаа нарийн мэргэжлийн эмчийн оролцоотойгоор дүгнэлт гаргуулан баталгаажуулж байх	-	Зөвлөмж өгөх	Дарга , нягтлан бодогч	Л.Билэгдэмбэрэл Н.Ариунтуяа
2	Асаргааны тэтгэмж олгохдоо зарим иргэдийн аймгийн ЭХМКомиссын акт болон сумын эрхлэгч их эмчийн тодорхойлолтын хугацаа баримтлаагүй	635.6	Төлбөрийн акт		
ДҮН		635.6			

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР